



2012 оны 11 сарын 02  
(3-р хэвлэл)

# МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ И-СОНИН

## “Монголын хөрөнгө оруулалтын чуулга уулзалт – Цэвэр нүүрсний Азийн дээд хэмжээний уулзалт 2012” арга хэмжээ зохиогдоно.

### Мэдээний тойм:

- “Монголын хөрөнгө оруулалтын чуулга уулзалт – Цэвэр нүүрсний Азийн дээд хэмжээний уулзалт 2012” арга хэмжээ зохиогдоно.
- Зах зээлийн мэдээ
- Бүртгэлтэй компанийн мэдээ
- Арилжаанд оролцох эрхтэй компанийн тоо 50-д хүрлээ.

“Монголын хөрөнгийн бирж” ТӨХК несүүдэд хөрөнгө оруулалт хийхтэй холбо- нь БНХАУ-ын INBC Global байгууллагатай отой мэдээлэл авах, бусад компаниудын хамтран “Монголын хөрөнгө оруулалтын бизнестэй танилцаж, өөрийн бизнесийг чуулга уулзалт - Цэвэр нүүрсний Азийн бусдад танилцуулах, цэвэр нүүрсний дээд хэмжээний уулзалт 2012” арга сүүлийн үеийн технологи, ололт амжилт, хэмжээг БНХАУ-ын Шанхай хотод 2012 шийдлүүдтэй /нүүрснээс хий гаргах, оны 12-р сарын 10-наас 12-ны өдрүүдэд шингэрүүлсэн түлш, нүүрсийг газар доор зохион байгуулах гэж байна. хийжүүлэх гэх мэт/ танилцах боломжтой.

Энэхүү чуулга уулзалтад Монгол Улсад хөрөнгө оруулдаг болон хөрөнгө оруулахаар сонирхож буй олон улсын болон БНХАУ-ын томоохон хөрөнгө оруулагчид, бизнесийн болон санхүүгийн салбарынхан оролцох бөгөөд Монголын томоохон компаниуд, түүний дотор уул уурхай, дэд бүтэц, эрчим хүч, санхүүгийн үйлчилгээ, хөрөнгө оруулалтын салбарын компаниуд оролцох болно.


Уг чуулга уулзалтын үеэр, Монгол Улсын хөрөнгө оруулалтын орчны талаар хэлэлцүүлэг өрнүүлж, Монголын биз-

Энэхүү чуулга уулзалтад оролцсо- ноор гадаад, дотоодын төр засгийн өндөр албан тушаалтнууд, бизнесийн лидерүүд, зөвлөхүүд, мэргэжилтнүүд болон олон ул- сын хөрөнгө оруулагчидтай холбоо тогто- ох, бизнесийн шинэ хамтрагчидтай болох боломжтой.

Чуулга уулзалтын талаарх дэлгэрэнгүй мэдээллийг манай цахим хуу- дас /www.mse.mn/-аас үзнэ үү.

### Зах зээлийн мэдээ

### TOP-20 индексийн үзүүлэлт /сүүлийн 2 долоо хоногт/



### Монголын хөрөнгийн бирж

#### 2 долоо хоногийн:

Арилжигдсан ширхэг	514.5 мянга
Арилжигдсан дүн	237.7 сая.төг
Арилжигдсан компанийн тоо	51
Хамгийн их өсөлттэй:	

#### Хамгийн их бууралттай:

Алтайн зам /AZH/	+32.2%
Хар тарвагатай /TVT/	+14.9%
Газар сүлжмэл /SUL/	+11.1%
Шарын гол /SHG/	-25.0%
Эрээнцав /ECV/	-15.0%
Цагаан толгой /TSA/	-15.0%
Индекс	1,649.0 тэрбум.төг
Өөрчлөлт	15,980.12 / -3.44%

#### Зах зээлийн үнэлгээ:

TOP-20 индексийн өөрчлөлт:

Индекс:  
Вебсайт:

TOP-20  
www.mse.mn

2012 оны 10 сарын 22-ноос 2012 оны 11 сарын 02-ны хооронд нийт 10 удаагийн арилжаа явагдаж 51 компанийн 237.7 сая төгрөгийн үнийн дүн бүхий 514.5 мянган ширхэг хувьцаа арилжсан байна.

Уг хугацаанд хамгийн идэвхтэй арилжигдсан компани нь 'Э-транс логистикс' ХК /37.0 сая.төг/, 'АПУ' ХК /36.8 сая.төг/, 'Эсгийн гутал' ХК /24.8 сая.төг/ байсан байна.



## Бүртгэлтэй компанийн мэдээ

### "ЭРДЭНЭТ ХҮНС" ХК-ИЙН (MSE : TAS) 51 ХУВИЙГ ЭЗЭМШИГЧ ТАЛААС БУСАД ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ӨМЧЛӨЛД БАЙГАА ХУВЬЦААГ ХУДАЛДАН АВАХ САНАЛЫГ СЗХ ЗӨВШӨӨРЛӨӨ.

"Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай" хуулийн 6.1.1, 6.2.2, "Компанийн тухай" хуулийн 57.1, "Үнэт цаасны зах зээлийн тухай" хуулийн 11.2, 34.1.8, СЗХ-ны "Хувьцаат компанийн хувьцааг заавал болон сайн дурын үндсэн дээр худалдан авах санал гаргах ажиллагааны журам"-ыг тус тус үндэслэн, СЗХ-ноос "Эрдэнэт хүнс" ХК (MSE:TAS)-ийн нийт гаргасан 394,298 ширхэг хувьцааны 51 хувь буюу 201,091 ширхэг хувьцааг эзэмшигч нэгдмэл сонир-

холтой этгээд болох "Эрхэт трейд" ХХК, Г.Одгэрэл нараас тус хувьцаат компанийн бусад хувьцаа эзэмшигчдийн өмчлөлд байгаа нийт хувьцааны 49 хувь буюу 193,207 ширхэг хувьцааг, нэг бүрийг нь 926 /есөн зуун хорин зургаан/ төгрөгөөс доошгүй үнээр худалдан авах санал гаргасныг зөвшөөрч хүчинтэй байх хугацааг 2012 оны 10 дугаар сарын 25-ны өдрөөс эхлэн ажлын 60 хоног байхаар тогтоол гаргав.

### СЗХ-ООС "ДЭЛГЭРЭХ ХҮНС" ХК-ИЙН (MSE: DHO) ҮНЭТ ЦААСЫГ БҮРТГЭЛЭЭС ХАСАХ ТОГТООЛ ГАРГАЛАА.

СЗХ-ны 2012 оны 10-р сарын 25-ны өдрийн 318 тоот тогтоолоор, "Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай" хуулийн 6.1.1, 6.1.2, "Үнэт цаасны зах зээлийн тухай" хуулийн 34.1.1, "Компанийн

тухай" хуулийн 23 дугаар зүйл, СЗХ-ны "Нийтэд санал болгон худалдах үнэт цаасыг бүртгэх, анхдагч зах зээлд санал болгох, худалдах тухай журам"-ын 8.1 дэх заалтыг тус тус үндэслэн "Дэлгэрэх хүнс" ХК-ийн нийтэд санал болгон гаргасан нийт 146,387 /нэг зуун дөчин зургаан мянга гурван зуун наян долоо/ ширхэг хувьцааг үнэт цаасны бүртгэлээс хасах тухай тогтоол гаргасан байна.

Бүртгэлээс хасагдах болсон шалтгаан нь тус компани хэлбэрээ өөрчлөн хувьцаат компанийн хэлбэрээс хаалттай хязгаар-лагдмал хариуцлагатай компанийн хэлбэрт шилжих болсонтой холбоотой юм.

Уг хувьцааг үнэт цаасны бүртгэлээс хасахтай холбоотойгоор, компанийн хувьцаа эзэмшигчид "Компанийн тухай" хуулийн 24.1, 53.1 дэх заалтын дагуу өөрийн


эзэмшиж буй хувьцааг компанид эргүүлэн авахыг шаардах эрх үүсч байгаа юм.

Хувьцаагаа компанид эргүүлэн авахыг шаардах эрх үүссэн хувьцаа эзэмшигчдийн эзэмшилд байгаа хувьцаанд ногдох хувийн мөнгийг нэгж хувьцаанд 450 /дөрвөн зуун тавь/ төгрөгөөр тооцсон байна.

Мөн шаардах эрхээ хэрэгжүүлээгүй хувьцаа эзэмшигчид түүний дансанд байршуулсан ногдол хувийн мөнгөн хөрөнгийг авалгүйгээр хаалттай компанийн хувьцаа эзэмшигчээр үлдэх хүсэлтийг хэдийд ч гаргах боломжтой.

## Арилжаанд оролцох эрхтэй компаниудын тоо 50-д хүрлээ.

Төлбөрийн баталгааны санд хөрөнгө байршуулсан 56 компани, МХБ-тэй хамтран ажиллах гэрээг шинэчлэн байгуулсан 71 компани, төлбөр тооцоо гүйцэтгэгч банктэй гэрээ байгуулсан 56 компани, барьцаа хөрөнгө байршуулсан 50 компани тус тус байгаа бөгөөд Монголын хөрөнгийн биржийн шинэ систем, дүрэм журмын дагуу



тавигдаж буй шаардлагыг хангасан брокер дилерийн

компанийн тоо хоёроор нэмэгдэж нийт 50 компани

арилжаанд оролцох эрхтэй боллоо.